



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 4524

Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын барилга угсралтын ажлын хяналтын төсвийн тоо хэмжээнд тусгагдаагүй буулгалтын ажлын зөрүү зардалд 41,618,130 (дөчин нэгэн сая зургаан зуун арван найман мянга нэг зуун гуч) төгрөгийг гүйцэтгэгч “Гүн чимэгтэй” ХХК-д олгосугай.

2. Дээрх зардалд нэмэлт гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Ариунболд)-д даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах санхүүжилтиг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101112